



МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: **Ухнаагийн Хүрэлсүх**
Засгийн газрын тэргүүн: **Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ**

УИХ-д өргөн баригдсан хуулийн төслүүдэд төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд шинэ хязгаарлалт үүсгэх, уул уурхай, бусад хөгжлийн төслийг эсэргүүцсэн жагсагчдыг хорих зүйл заалт агуулагджээ. Эрх баригчид уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн байгаль орчны доройтлоос малчдыг хамгаалсангүй. Хүний эрх хамгаалагчид айлган сүрдүүлэлтэд өртөж, цагдаад байцаагджээ. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулагдсан ч, хоригдогсдыг эрүүдэн шүүсэн, тэдэнтэй зүй бус харьцсан гэх гомдлууд гарсаар байна.

Эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрх чөлөө

Төрийн бус байгууллагын хууль ёсны үйл ажиллагааг хязгаарлахуйц хуулийн төсөл УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд үлдлээ. Анх 2021 онд өргөн баригдсан уг хуулийн төсөлд ТББ-д хяналт тавих Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл байгуулахаар тусгасан ба тус зөвлөлийн тодорхой бус, хэт ерөнхий эрх мэдэл нь ТББ-ын дотоод хэрэгт зүй бусаар хөндлөнгөөс оролцох, захиргааны дарамт шахалт үзүүлэх эрсдэлтэй байгаа бөгөөд хуулийн төсөлд мөн хууль ёсны үйл ажиллагааг нь хориглох, санхүүжилтийг нь хязгаарлах заалтууд ч багтжээ.

Уул уурхай, бусад хөгжлийн төсөлд саад учруулсан бол хорих ял оногдуулах нөхцлийг тусгасан Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг тавдугаар сард Засгийн газраас өргөн барьсан. Үүний дараахан нийслэл Улаанбаатар хотод говийн бүсийн малчид уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцэж, эдийн засаг, нийгмийн эрхээ хамгаалахыг шаардан жагсаал зохион байгуулжээ.

Байгаль орчны доройтол, эдийн засаг, нийгэм, соёлын эрх

Говийн бүсэд нүүрсний болон бусад уурхайн үйл ажиллагаа нь бэлчээр сүйтгэж, гүний усыг бохирдуулж, усны бусад эх үүсвэрийг шавхсан.

Түүнчлэн уул уурхай нь хөрсний доройтолд хүргэж, бүс нутгийн малчдын эрүүл мэнд, амьжиргаанд сөргөөр нөлөөлөв.

Засгийн газар уул уурхайн нөлөөлөлд өртсөн малчидтай хангалттай зөвлөлдөхгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас нүүлгэн шилжүүлсэн болон бусад байдлаар нөлөөлөлд өртсөн хүмүүсийг зохих нөхөх олговор, орон байраар хангах зэрэг зайлшгүй шаардлагатай үйлчилгээ, нийгмийн хамгаалал хүртэх боломжоор хангаж чадсангүй.

Хүний эрх хамгаалагчид

Засгийн газраас зарим хүний эрх хамгаалагчдыг гадаадын тагнуул хэмээн нийтэд зарлах, үндэсний хөгжлийн төслийг гацаагч гэж шүүмжлэх зэргээр гутаах кампанит ажлыг явуулсан.

Эрх баригчид хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаанд саад учруулахын тулд мөрдөн шалгах болсон. Наймдугаар сард Тагнуулын ерөнхий газраас хөгжлийн төслүүдээс учирч буй байгаль орчны доройтол, хүний эрхийн зөрчлийг илчлэх ажилтай нь холбогдуулан Дүгэрсүрэнгийн Сүхгэрэлийг “гадаадын тагнуулын байгууллага, төлөөлөгчтэй хууль бусаар хамтран ажилласан” гэх зүйлчлэлээр шалгаж эхэлсэн.

Орон байраар хангагдах эрх

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль тогтоомж дахь хуулийн хамгаалалт хангалтгүй байгаагаас болж Улаанбаатар хотод дор хаяж 47 өрх орон гэргүй болсон. Зарим барилгын компани бүтээн байгуулалтад зориулж иргэдийн газрыг зөвшөөрөлгүй, зохих нөхөх олговоргүйгээр авсан.

Эрүү шүүлт ба бусад зүй бус харьцаа

Долдугаар сард Засгийн газар эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулсан. Хэдий тийм боловч цагдан хорих газарт хэрэг хүлээлгэхийн тулд эрүүдэн шүүж, зүй бус харьцсан тохиолдол гарсныг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлсэн.

Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа улс төрийн үзэл баримтлал, шашин, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байж, гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнл

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж, #АВ төвийн 11 давхар 1101 тоот

Утас/Факс: 976-7000-4705

members@amnesty.mn

www.amnesty.mn